



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# Хөдөлмөрийн салбарын танилцуулга, 2020 он



УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН

## ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН

Б.Батдаваа	ҮСХ-ны дарга
А.Амарбал	ҮСХ-ны ХАНСГ-ын дарга
Э.Гантуяа	ҮСХ-ны ХАНСГ-ын ахлах статистикч

### ТАНИЛЦУУЛГЫГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН

Б.Уламбадрах	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Н.Болорчимэг	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Н.Алтантүлхүүр	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Б.Гэрэл	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч



#### МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу  
Засгийн газрын III байр



976-11-326414, 976-51-265543



[www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn)



[information@nso.mn](mailto:information@nso.mn)

Энэхүү танилцуулгад агуулагдсан гол мэдээллүүд Үндэсний статистикийн хорооны мэдээллийн санд байдаг бөгөөд хувь хүн, албан байгууллага ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүйгээр бүрэн ашиглаж болно.

## АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	5
1. Хөдөлмөрийн статистик, ач холбогдол .....	6
2. Хөдөлмөрийн статистикийн түүх .....	6
3. Мэдээллийн эх үүсвэр.....	8
4. Ойлголт тодорхойлолт.....	9
<b>ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....</b>	<b>12</b>
1.1. АРГАЧЛАЛЫН ШИНЭЧЛЭЛТ .....	13
1.2. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	14
<b>АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД .....</b>	<b>19</b>
2.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ .....	20
2.2. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	21
<b>ТӨРИЙН АЛБАН ХААГЧ .....</b>	<b>26</b>
3.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ .....	27
3.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	29
<b>МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БУЙ АЖИЛЛАГЧ .....</b>	<b>32</b>
4.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ .....	33
4.2. МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА ГАДААД ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	34
<b>ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН .....</b>	<b>38</b>
5.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ДАВТАМЖ, УРСГАЛ .....	39
5.2. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНЫ СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	39
<b>ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО.....</b>	<b>41</b>
6.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ.....	42
6.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	43

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.1. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, ОНЫ ЭЦЭСТ ...	14
ХҮСНЭГТ 1.2. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, МЯНГАН ХҮН .....	14
ХҮСНЭГТ 1.3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....	17
ХҮСНЭГТ 1.4. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГЖЭЭР .....	18
ХҮСНЭГТ 2.1. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХӨДӨЛГӨӨНӨӨР, МЯНГАН ХҮНЭЭР .....	22
ХҮСНЭГТ 4.1. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛААР .....	34
ХҮСНЭГТ 4.2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, УЛС ОРНООР .....	35
ХҮСНЭГТ 4.3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР .....	36
ХҮСНЭГТ 5.1. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН .....	39
ХҮСНЭГТ 5.2. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНД ХАМРАГДАГЧИД, САЛБАРААР .....	39
ХҮСНЭГТ 5.3. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНД ХАМРАГДСАН АЖИЛЛАГЧИД, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР .....	40
ХҮСНЭГТ 6.1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧ АЙМАГ, НИЙСЛЭЛ, БҮСЭЭР, 2016-2020 ОН .....	43
ХҮСНЭГТ 6.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2016-2020 ОН .....	44
ХҮСНЭГТ 6.3. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД ХЭЛБЭР, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР 2016-2020 ОН .....	45
ХҮСНЭГТ 6.4. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР 2016-2020 ОН .....	47
ХҮСНЭГТ 6.5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР .....	48
ХҮСНЭГТ 6.6. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, ЭЗҮА-НЫ САЛБАР, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР, 2020 ОН .....	49
ХҮСНЭГТ 6.7. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, ГАРСАН ШАЛТГААН УЛИРЛААР, 2020 ОН .....	51
ХҮСНЭГТ 6.8. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР УЛИРЛААР, 2020 ОН .....	52

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.1. АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР, ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСНААР.....	15
ЗУРАГ 1.2. АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСНААР.....	15
ЗУРАГ 1.3. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ХҮЙС, БАЙРШЛААР .....	17
ЗУРАГ 1.4. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ХҮЙС, БАЙРШЛААР .....	18
ЗУРАГ 2.1. АЖИЛ ХАЙЖ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД, ТӨРӨЛ.....	21
ЗУРАГ 2.2. АЖИЛ ХАЙЖ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР .....	21
ЗУРАГ 2.3. АЖИЛ ХАЙЖ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД, САРААР.....	22
ЗУРАГ 2.4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, САРААР.....	23
ЗУРАГ 2.5. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР .....	23
ЗУРАГ 2.6. ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, АЖИЛ ХАЙЖ БУЙ ШАЛТГААНААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОНЫ ЭЦЭСТ .....	24
ЗУРАГ 2.7. АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ХҮН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОНЫ ЭЦЭСТ.....	24
ЗУРАГ 2.8. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2020 ОН .....	25
ЗУРАГ 2.9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХҮЙСЭЭР .....	25
ЗУРАГ 3.1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, АНГИЛЛААР.....	29
ЗУРАГ 3.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ АЛБАН ТУШААЛЫН ТӨРЛӨӨР.....	29
ЗУРАГ 3.3. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, ХҮНЭЭР.....	29
ЗУРАГ 3.4. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, БАЙРШЛААР .....	30
ЗУРАГ 3.5. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, НАСНЫ БҮЛГЭЭР.....	30
ЗУРАГ 3.6. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ДУНДАЖ НАСНЫ ӨӨРЧЛӨЛТ (СҮҮЛИЙН 10 ЖИЛЭЭР) .....	30
ЗУРАГ 3.7. ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ХҮЙСЭЭР .....	31
ЗУРАГ 3.7. ТӨРИЙН АЛБАНД АЖИЛЛАГЧДЫН ТОО, САЛБАРААР .....	31
ЗУРАГ 4.1 ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛААР, ХУВИАР.....	34
ЗУРАГ 4.2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, УЛС ОРНООР, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР .....	35
ЗУРАГ 4.3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛГЭЭР, ЭЗЛЭХ ХУВИАР.....	36
ЗУРАГ 4.4. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР .....	37
ЗУРАГ 5.1. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН, ШИЙДЭГДСЭН БАЙДЛААР.....	40
ЗУРАГ 6.1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, 2016-2020 ОН.....	44
ЗУРАГ 6.2. ОСОЛДОГЧИД, НАСНЫ БҮЛГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	44
ЗУРАГ 6.3. АЖЛЫН БАЙР ДАХЬ ХҮНД БОЛОН ХӨНГӨН ОСОЛ ГЭМТЛИЙН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН (100.000 АЖИЛЛАГЧ ТУТАМД).....	46
ЗУРАГ 6.4. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД ХЭЛБЭР, ЭЗҮА-НЫ САЛБАРААР, САЛБАРЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	46
ЗУРАГ 6.5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧ, АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХҮЙСЭЭР 2020 ОН .....	48
ЗУРАГ 6.6. ОСОЛДОГЧИД, ОСОЛД ОРСОН ШАЛТГААНААР, 2020ОН .....	50
ЗУРАГ 6.7. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, НАС БАРАЛТ, УЛИРЛААР, 2017-2020 ОН....	50
ЗУРАГ 6.8. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, ХЭЛБЭР, УЛИРЛААР 2020 ОН .....	51

## УДИРТГАЛ

### 1. Хөдөлмөрийн статистик, ач холбогдол

Хөдөлмөрийн статистик гэдэг нь:


- хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлох;
- анализ хийхэд ашигладаг тоон мэдээллийн багц юм.

Хөдөлмөрийн статистикийн ач холбогдол: Хөдөлмөрийн зах зээлийн статистикийн үндсэн үзүүлэлтүүд нь Монгол Улсын хүн ам, нийгмийн статистикийн асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах болон шийдвэр гаргах, дүгнэх түвшинд ашиглагдах мэдээллийн чухал эх үүсвэр юм. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн статистикийн тоон мэдээлэл яагаад чухал вэ? Үүнийг хамгийн энгийнээр тайлбарлавал, олон айл өрхийн амьжиргааны түвшин нь тухайн өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтээс шууд хамаарч байдаг. Иймээс энэхүү танилцуулгаар хөдөлмөрийн 5 дэд салбарын статистикийн мэдээллийн өнөөгийн байдал, өөрчлөлтийг боломжит оноор нэгтгэн бэлтгэлээ.

### 2. Хөдөлмөрийн статистикийн түүх

Хөдөлмөрийн статистикийн түүх, хөгжлийг авч үзэхэд 1960 он хүртэлх ажиллах хүч, цалингийн статистик нь үйлдвэржсэн салбарын хөгжилтэй уялдан гол төлөв нягтлан бодох бүртгэлд тусгагдаж байжээ. Ажиллагчдын тоо, цалингийн фондыг улс ардын аж ахуйн хэмжээгээр, салбараар статистикийн мэдээллээр 1940-өөд оны сүүлч болтол гаргаж байгаагүй. “Үйлдвэрийн газрууд төлөвлөгөө ёсоор байвал зохихоос 2825 ажилчид дутагдаж байхад 1947 оны тэргүүний хагаст бүрэн бус мэдээгээр 1018 ажилчид ажлаа орхиж явсан ба халагдсан байна” гэж МАХН-ын 11 дүгээр их хурлын тайлан илтгэлд тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөт жилүүдэд үйлдвэр аж ахуйн газруудад ажиллагчдын тоо, хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл байсан гэж үзэх үндэстэй. Эдгээрийн үр дүнд статистикийн анхны эмхтгэлд ажилчин, албан хаагчид, хөдөө аж ахуйн гишүүдийн тоо, хөдөлмөрийн бүтээмж зэрэг хөдөлмөр, цалингийн зарим үзүүлэлтийн тоо материалыг оруулж байжээ.

### ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ



**1965:** Хүн амын 1963 оны тооллогын материал дээр үндэслэн Хөдөлмөрийн нөөцийн балансыг боловсруулж, 1965 оноос эхлэн хөдөлмөрийн статистикийг аймаг, нийслэлийн түвшинд бий болгосон.

**1992:** Үүний дараа зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд ажилгүйчүүдийн талаарх ойлголт, тодорхойлолт өмнөхөөсөө эрс ялгаатай болсноор ажилгүйчүүдийн сарын мэдээг 1992 оноос эхлэн гаргаж эхэлсэн. Энэ тайланг тухайн үед шинээр үүсэж байсан хөдөлмөрийн захуудаар дамжуулан авч байлаа.

**2006:** Монгол Улсад хөдөлмөрийн статистикийг боловсронгуй болгох зорилгоор АХС-г 2002-2003 онд олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон.

Уг судалгааны үр дүнд үндэслэн “ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, үр дүнг дүгнэхэд шаардлагатай статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, мэдээллийн давтамжийг тогтмолжуулах цаашлаад хөдөлмөрийн статистикийн системийг боловсронгуй болгох” шаардлагатай гэж дүгнэсэн.

Иймд Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд “Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байх”-аар 2004 онд нэмэлтээр тусгаж, ҮСХ нь Ажиллах хүчний судалгааг 2006 оноос эхлэн тогтмол явуулж, үр дүнг улирал жилээр тархааж байна. Энэ судалгааны үр дүн нь хөдөлмөрийн статистикийн мэдээллийн гол эх үүсвэр болж өгдөг.

**2005:** Үндэсний статистикийн хорооноос Төрийн албаны зөвлөлийн “Монгол Улсын төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх статистикийн тойм” бүхий мэдээллийн эх үүсвэртэйгээр төрийн албан хаагчийн тоог нийтэд албан ёсны статистикийн мэдээлэл болгон жилийн давтамжтайгаар тархаах болсон.

**2009:** Түүнчлэн улсын хэмжээнд 2009 оноос өмнөх жилүүдэд ажилгүйдлийн түвшнийг бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцдог байсан бол 2009 онд “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлал” Үндэсний статистикийн хорооны дарга, хуучнаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар шинэчлэн батлагдсаны дагуу ажилгүйдлийн түвшнийг Ажиллах хүчний судалгааны үр дүнгээрх нийт ажилгүй иргэдийн тоогоор тооцох болсон.

Мөн Үндэсний статистикийн хорооноос Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй гадаад ажиллагчдын мэдээг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны мэдээллийн эх үүсвэртэйгээр албан ёсны статистикийн мэдээлэл болгон хагас жилийн, 2019 оноос эхлэн улирлын давтамжтайгаар тархааж болсон.

**2016:** ОУХБ-т хүсэлт гарган, Монгол Улсын хөдөлмөрийн статистикийн системд ОУХБ-ын зөвлөх, Владимир Ганта /хуучнаар Молдав Улсын статистик, одоо ОУХБ-т/-аар үнэлгээ хийлгэн, үнэлгээний дүн, зөвлөмжийг хэлэлцэх уулзалтыг зохион байгуулсан. Цогц үнэлгээний гол зорилго нь МУ-н хөдөлмөрийн статистикийн системийн ойлголт, тодорхойлолт, аргачлал, хэрэгжилт, үзүүлэлтүүдийг олон улсын хөдөлмөрийн статистикийн стандарт, зөвлөмжтэй харьцуулж, ялгаатай болон цаашид хийх зүйлсийг олж тогтоох, хөдөлмөрийн статистикийн чадавхыг сайжруулахад оршсон. Энэхүү цогц үнэлгээний үр дүн, зөвлөмжид үндэслэн ҮСХ, ОУХБ-ын хамтын ажиллагаа улам өргөжин, дараах ажлуудыг хэрэгжүүлэх эхлэл тавигдсан. Үүнд:

- ✓ ОУХС-ын 19-р бага хурлын тогтоолд тусгагдсан хөдөлмөрийн олон улсын шинэ стандартыг өөрийн орны онцлогт нийцүүлэн, нэвтрүүлэх;
- ✓ Зохистой хөдөлмөрийг хангах замаар 2030 он хүртэлх ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь” анхны төдийгүй улс орнуудад жишиг болохуйц тайланг англи, монгол хэл дээр хамтран бэлтгэн ажлын суурь тавигдсан.

Мөн Үндэсний статистикийн хорооноос Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-ын мэдээллийн эх үүсвэртэйгээр нийтэд албан ёсны статистикийн мэдээлэл болгон улирлын давтамжтайгаар тархаах болсон.

**2017:** Үндэсний статистикийн хорооноос Хөдөлмөрийн хамтын маргааны мэдээг ХНХЯ-ны мэдээллийн эх үүсвэртэйгээр албан ёсны статистикийн мэдээлэл болгон жилийн давтамжтайгаар тархааж болсон.

**2019:** ҮСХ, ОУХБ-ын хамтын ажиллагааны хүрээнд ОУХС-ын 19-р бага хурлын тогтоолд тусгагдсан хөдөлмөрийн олон улсын шинэ стандартыг өөрийн орны онцлогт нийцүүлэн, нэвтрүүлэх зорилгоор 2017, 2018 онуудад туршилтын судалгааг зохион байгуулан, 2019 оноос шинэ аргачлалыг нэвтрүүлсэн. Аргачлалын шинэчлэлтийн талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тусгасан болно. Түүнчлэн 2016 онд ОУХБ-ын зөвлөмжийн дагуу АХС-нд үнэлгээ хийж, түүврийн дизайныг шинэчлэх зөвлөмж өгсний дагуу 2018 онд ОУХБ-аас санал болгосон олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, туршилт судалгаа явуулан, 2019 оноос шинэчилсэн түүврийн дизайн болох хагас панел буюу ротациональ судалгааны дизайнд шилжсэн.

### 3. Мэдээллийн эх үүсвэр

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын статистикийн тухай хуульд заагдсан хөдөлмөрийн статистикийн бүхий л мэдээллийг дараах эх үүсвэртэйгээр албан ёсны статистикийн мэдээлэл болгон тархааж байна.

#### ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

№	Дэд салбар	Эх үүсвэр	Эхэлсэн хугацаа	Давтамж	Монгол Улсын Статистикийн тухай хууль
1	Ажиллах хүчний судалгаа	ҮСХ	2002-2003 2006 ~	Улирал, жил	7.1.ё: “Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байх”.
2	Ажил хайгч иргэн, бүртгэлтэй ажилгүй иргэд	ХНХЯ	БАИ-2008 АХИ-2014	Сар бүр	-
3	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй гадаад ажиллагчид	ХНХЯ	2009-2019 2019 ~	Хагас жил, улирал	-
4	Төрийн албан хаагчид	ТАЗ	2005 ~	Жил	-
5	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого	МХЕГ	2016 ~	Улирал	6. 2.о: үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт, түүнийг гаргах.
6	Хөдөлмөрийн хамтын маргаан	ХНХЯ	2017 ~	Жил	6.2.п: хөдөлмөрийн маргааны албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт, түүнийг гаргах.



## 4. Ойлголт тодорхойлолт

Хөдөлмөрийн зах зээл	Ажиллах хүчийг худалдах, худалдан авах субъектүүдийн хоорондын харилцаа.
Хөдөлмөрийн насны хүн ам	15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.
Ажиллах хүч	тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас энэ боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.
Ажиллагч	Зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ.
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	Хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг Ажилгүй хүн, Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон Боломжит ажиллах хүчээр хэмжинэ.
Ажилгүй хүн	Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм. Үүнд: а. хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг; б. ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг; в. ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	Тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ.
Боломжит ажиллах хүч	Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм. Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд: а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн; б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.
Албан бус салбар	Хөдөө аж ахуйн бус салбарт орлого олох зорилготойгоор зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг өрхийн хоршоологдоогүй аж ахуй нэгжийг ойлгоно. Тэд ямар нэгэн бүрэн хөтөлсөн данс тооцоогүй, албан ёсны бүртгэлийг дагаж мөрддөггүй буюу аж ахуйн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, орлогын албан татварын талаарх мэдээлэлд бүрэн хамрагдаагүй байдаг.
Албан салбар	Төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн тогтолцоотой үйлдвэрийн газар буюу зах зээлийн бус хуулийн этгээдүүд болон зах зээлд борлуулах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй албан ёсны бүртгэлд бүрэн хамрагдсан хуулийн этгээд, хуулийн этгээдийн хяналт дор (орлогын албан татварын талаарх мэдээлэлд бүрэн хамрагдсан) үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, өрхийн аж ахуйн үйл ажиллагаа юм.
Албан бус хөдөлмөр эрхлэгч	Албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчид дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд: а. Тухайн хугацаанд хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, орлогын албан татвар, өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч; б. Албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч; г. Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч; д. Хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүд орно.
Албан бус салбарт ажиллагч	Хөдөлмөр эрхлэлтийн статусаас үл хамааран, тухайн хугацаанд наад зах нь нэг албан бус салбар дахь эдийн засгийн нэгжид ажиллаж байгаа ажиллагч юм.

Албан салбарт албан бус хөдөлмөр эрхлэгч	Албан салбар дахь албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.
Ажил хайгч иргэн	Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг хэлнэ.
Бүртгэлтэй ажилгүй иргэд	Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.
Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн	Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.
Үйлдвэрлэлийн осол	Хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг хэлнэ.
Хурц хордлого	Цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг хэлнэ.
Осолдогч	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг хэлнэ.
Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан	Иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.
Бүлэг осол, хурц хордлого	Нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг хэлнэ.
Хөдөлмөрийн хамтын маргаан	Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, биелүүлэх, биелэлтэд нь хяналт тавих явцад гэрээ, хэлэлцээрт оролцогч талуудын хооронд үүссэн саналын зөрүүг хэлнэ.
Ажил хаялт (страйк)	Хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх зорилгоор ажилтнаас үүрэгт ажлаа сайн дурын үндсэн дээр тодорхой хугацаагаар бүрэн буюу хэсэгчлэн түр зогсоохыг хэлнэ.
Ажлын байрыг түр хаах (локаут)	Ажил олгогч нь ажиллагчдын тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэх, эсэргүүцэх, эсхүл гомдлоо илэрхийлэх зорилгоор ажил олгогч нэг буюу хэд хэдэн ажлын байрыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр хаах, эсхүл ажиллагчдын ажлын хэвийн үйл ажиллагаа явуулахад нь саад учруулахыг хэлнэ.
Ажлын байрыг түр хаах (пикет)	Ажил хаялтад оролцогчдын ажлын байранд ажилтан түр ажиллуулахгүй байх зорилгоор ажилтны төлөөлөгчид нь аж ахуйн нэгж, байгууллагыг түр хаахыг хэлнэ.
Төрийн албан хаагч	Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ.

## ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



## 1.1. АРГАЧЛАЛЫН ШИНЭЧЛЭЛТ

Сүүлийн жилүүдэд манай улсад төдийгүй олон улсад ажилгүй хүн, ажилгүйдлийн түвшин нь ажиллах хүчний дутуу ашиглалтыг бүрэн харуулж чадахгүй байгаа тул хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлоход дутагдалтай байна гэдэг асуудал яригдсан. Иймд ОУХБ-аас тэртээ 1982 онд баталсан Хөдөлмөрийн статистикийн тодорхойлолт, аргачлалаа 2013 онд шинэчилсэн. Иймд хөдөлмөрийн зах зээл маш хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн цаг үетэй хөл нийлүүлэн, нөхцөл байдлыг бодитоор харахын тулд Олон улсын хөдөлмөрийн статистикчид (ОУХС)-ын 19-р бага хурлын тогтоолыг өөрийн орны онцлогт тусган, ойлголт, тодорхойлолт, аргачлалаа шинэчлэн боловсронгуй болгох шаардлагын дагуу 2019 оны 1 дүгээр сараас эхлэн Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг мөрдөж байна.

Гол шинэчлэлт:

- **Хөдөлмөрийн насны** дээд хязгаарыг тогтоож өгөхгүйгээр, 15 ба түүнээс дээш болгосон.
- **Ажиллагч** гэдэгт зөвхөн цалин, ашгийн төлөө ажиллаж байгаа хүнийг хамааруулсан. Өмнөх аргачлалын дутуу цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан нь ажиллагч болж байсан бол шинэ аргачлалаар ажиллагч болохгүй, ажилгүй хүн эсвэл ажиллах хүчнээс гадуурх хүн ам болж байгаа.
- Ажиллагчдын **үндсэн ажлын** шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.
- **Ажилгүй хүний** шалгуур шинэчлэгдэн, цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан болон тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа гэсэн 3 шалгуурыг хангасан хүнийг хэлэх болсон. Өмнө нь "сүүлийн 2 шалгуурын аль нэгийг нь хангах" гэж авч үзэж байсан. Мөн насны дээд хязгааргүй болсон.
- Ажиллах хүчний дутуу ашиглалтыг хэмжих уламжлалт үзүүлэлт буюу ажилгүй хүн, ажилгүйдлийн түвшнээс илүү өргөн хүрээний **хөдөлмөрийн дутуу ашиглалт, түүний түвшнүүд** бүхий шинэ үзүүлэлтүүдийг бий болгосон.

Гол ач холбогдол:

- Амьдрал дээр хөдөлмөрийн наснаас дээш насны хүн хөдөлмөр эрхэлж эсвэл хөдөлмөрлөх хүсэл зорилготой байна (жолооч, оёдолчин гэх мэт энгийн ажил мэргэжлээс эхлээд тодорхой ур чадвар шаардсан дотоодын зөвлөхөөр ч ажиллаж байна). Иймд хөдөлмөрийн насны хүн амын насны дээд хязгаарыг байхгүй болгосон. Ингэснээр хөдөлмөрийн статистикийн хамрах хүрээг нэмэгдүүлэн хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, цаашлаад ДНБ-ний тооцоолол илүү нарийн илэрхийлэгдэх юм.
- Хөдөлмөрийн дутуу ашиглалтын шинэ үзүүлэлтийг бий болгосноор хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ нь хангагдахгүй байгаа хүн амыг бүрэн илэрхийлэх, цаашлаад хэнд ямар бодлого хөтөлбөрийг чиглүүлэх вэ гэдэг илүү дэлгэрэнгүй суурь тоон мэдээлэл бий болох юм. Өөрөөр хэлбэл, улс орнууд ажилгүйдлийг бууруулах бодлогын суурь тоог зөвхөн ажилгүй хүнээр авахад, хэрэгжүүлэх явцад ажилгүй хүн бус бага цагаар ажиллаж байгаа, нэмэлт ажил хайж, хийхэд бэлэн байгаа ажиллагчид ч хамрагдаж байна. Энэ нь хөтөлбөрийн зорилтын үр дүн хангалттай хэрэгжихгүйд хүргэж байна гэж үзэн ОУХБ-аас хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтийг шинээр бий болгосон.

## 1.2. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн зах зээлийн гол мэдээллийн эх үүсвэр нь “Ажиллах хүчний судалгаа (АХС)” бөгөөд, 2002-2003 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын санхүүжилтээр анх удаа олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан. 2004 онд Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд нэмэлт заалт оруулсны дагуу 2006 оноос эхлэн АХС-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархааж байна.

Ажиллах хүчний судалгааг 2019 оноос эхлэн Хөдөлмөрийн статистикийн шинэ ойлголт, аргачлалын дагуу явуулж байгаа нь бодлого, төлөвлөлтөд ашиглах, бодлогын шинжилгээ хийхэд хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүд, тэдгээрийн түвшин гэх мэт илүү дэлгэрэнгүй мэдээллээр хангах ач холбогдолтой болсон. Мөн албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ямар секторт (албан болон албан бус) ажиллаж байгааг тодорхойлох мэдээллийг бий болгож, ангилан харуулсан.

Энэ бүлэгт уг судалгааны 2020 оны жилийн үр дүнг товч танилцуулах бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг Ажиллах хүчний судалгааны 2020 оны тусгайлсан тайлангаас авах боломжтой.

Энэхүү бүлэгтээ хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтийг танилцуулахаас өмнө хөдөлмөрийн насны хүн амын насны бүтцийг танилцуулъя. Учир нь ажиллах хүчний тоо хэмжээ, өөрчлөлтөд хүн амын насны бүтэц ихээхэн нөлөөлдөг.

Монгол Улсын суурийн хүн ам 2020 оны эцэст 2.2 сая (67.9%) нь хөдөлмөрийн буюу 15 ба түүнээс дээш насны хүн ам байгаа нь 2019 оны эцсээс 24.2 мянган хүнээр хүнээр нэмэгдсэн байна. Хэдийгээр хөдөлмөрийн насны хүн ам өссөн ч тэдгээрийн нийт хүн амд эзлэх хувийн жин 0.4 пунктээр буурсан бөгөөд үүнд 0-14 насны хүн амын эзлэх хувийн жин 2019 оноос өссөн нь нөлөөлжээ. Энэ нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин буурсны илэрхийлэл юм. Мөн 2020 онд хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирж байгаа 15-24 насны залуучууд өмнөх оноос 5.2 (1.2%) мянгаар буурч, 60 ба түүнээс дээш насны хүн амын хүн ам өмнөх оноос 16.7 (7.2%) мянгаар өссөн байна.

### ХҮСНЭГТ 1.1. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, ОНЫ ЭЦЭСТ

Насны бүлэг	2019 оны эцэст	2020 оны эцэст	Зөрүү	
			Тоо	%
Бүгд	2,170,573	2,194,799	24,226	1.1
15-24	442,152	436,921	(5,231)	(1.2)
25-54	1,355,158	1,367,052	11,894	0.9
55-59	141,166	142,018	852	0.6
60+	232,097	248,808	16,711	7.2

Ажиллах хүчний судалгааны 2020 оны жилийн үр дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 1.2 сая нь ажиллах хүч байна. Ажиллах хүчний 1162.9 (93.0%) мянга нь ажиллагчид, 87.7 (7.0%) мянга нь ажилгүй хүн байна. Харин улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны ажиллах хүчнээс гадуурх хүн ам 877.5 мянга байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) улсын хэмжээнд 58.8 хувь, хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх 66.8 хувь, эмэгтэйчүүдийнх 51.8 хувьтай байна. Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин (ХЭТ) 54.6 хувь байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүд 61.9 хувь, эмэгтэйчүүд 48.3 хувь байна.

### ХҮСНЭГТ 1.2. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, МЯНГАН ХҮН

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Ажиллах хүч	1 357.4	1 358.6	1 273.9	1 250.6
Ажиллагчид	1 238.3	1 253.0	1 146.2	1 162.9
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	9.9	8.0	15.1	5.1
Ажилгүй хүн	119.1	105.6	127.7	87.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	863.0	868.0	832.2	877.5
Боломжит ажиллах хүч	-	-	58.8	70.7
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	-	-	773.4	806.8
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	61.1	61.0	60.5	58.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	55.8	56.3	54.4	54.6
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	-	-	15.1	12.4
Ажилгүйдлийн түвшин, %	8.8	7.8	10.0	7.0
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	-	-	11.2	7.4
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	-	-	14.0	12.0

Хөдөлмөрийн статусаар нь авч үзвэл, гүйцэтгэх гэрээлэгчид 12.7 мянга (90.1%), цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтнууд 2.2 мянга (89.0%)-аар буурсан байна.


#### ЗУРАГ 1.1. АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР, ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСНААР



Ажиллагчдын жилийн өөрчлөлтийг эдийн засгийн салбараар нь харвал, ХАА-н салбарын ажиллагчид 13.7 мянган хүн (4.7%), урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарын ажиллагчид 7.1 мянган хүн (39.9%) уул уурхай, олборлолтын салбарын ажиллагчид 6.3 мянган (11.0%)-аар буурсан, харин нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын ажиллагчид 15.8 мянга (35.8%), боловсролын салбарт 14.6 мянга (15.2%), барилгын салбарын ажиллагчид 8.4 мянга (12.3%)-аар нэмэгдсэн байна.

#### ЗУРАГ 1.2. АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

## САЛБАРААР, ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСНААР



Хөдөлмөрийн дутуу ашиглалт 2019 оны байдлаар улсын хэмжээнд 201.6 мянга байгаагаас боломжит ажиллах хүч 58.8 мянга (29.1%), ажилгүй хүн 127.7 мянга (63.3%), цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч 15.0 мянга (7.4%) байна. Харин 2020 онд хөдөлмөрийн дутуу ашиглалт 163.5 мянга болж 18.8 пунктээр буурсан байна. Үүнээс боломжит ажиллах хүч 70.7 мянга болж 20.2 пунктээр өссөн бол ажилгүй хүн 87.6 мянга болж 31.3 пунктээр, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч 5.1 мянга болж 65.8 пунктээр тус тус буурсан байна.




## ХҮСНЭГТ 1.3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2019	2020
Хөдөлмөрийн дутуу ашиглалт, мянган хүн	201 634	163 565
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	15 098	5 157
Ажилгүй хүн	127 736	87 696
Боломжит ажиллах хүч	58 800	70 712
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	15.1	12.4
Ажилгүйдлийн түвшин, %	10.0	7.0
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	11.2	7.4
Ажилгүй хүн болон БАХ-ний нэгдсэн түвшин %	14.0	12.0

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 2020 онд 12.4 хувь болж өмнөх оноос 2.7 пунктээр буурсан байна. Ажилгүйдлийн түвшин 7.0 хувь болж өмнөх оноос 3.0 пунктээр буурчээ. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 7.4 хувь болж өмнөх оноос 3.8 пунктээр, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 12.0 хувь болж 2.0 пунктээр буурсан байна.


Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдыг оруулсан дүнгээр албан бус хөдөлмөр эрхлэгчид 481.4 (41.1%) мянгад хүрч өмнөх оноос 5.3 (1.1%) мянгаар, хөдөө аж ахуйн бус салбарт ажиллагчид 209.9 (23.7%) мянгад хүрч өмнөх оноос 14.6 (7.5%) мянгаар өссөн байна.

## ЗУРАГ 1.3. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ХҮЙС, БАЙРШЛААР



ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 188.4 мянга (89.8%) нь хот, суурин газарт, 21.5 мянга (10.2%) нь хөдөө орон нутагт амьдарч байна. Харин ХАА-н салбарын ажиллагчдыг оруулсан дүнгээр буюу нийт ажиллагчдын хувьд, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 223.0 мянга (46.3%) нь хот, суурин газарт, 258.4 мянга (53.7%) нь хөдөө орон нутагт амьдарч байна. Энэ нь манай орны онцлог болох хөдөө орон нутагт өрхийн аж ахуйд суурилсан нүүдлийн мал аж ахуй эрхлэлт давамгайлдагтай холбоотой.

ЗУРАГ 1.4. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ХҮЙС, БАЙРШЛААР




Эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй нэгжийн хувьд албан бус сектор, өрхийн нэгжид төдийгүй албан секторт ч албан бус хөдөлмөр эрхлэлт байсаар байна. ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 60.3 хувь нь албан бус нэгжид, 38.1 хувь нь албан нэгжид, 1.6 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй өрхийн нэгжид ажиллаж байна.

ХҮСНЭГТ 1.4. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГЖЭЭР

Үйл ажиллагааны нэгж	2019			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД, ХАА-Н САЛБАР ОРСОН</b>	<b>476.1</b>	<b>270.8</b>	<b>205.3</b>	<b>481.4</b>	<b>284.3</b>	<b>197.1</b>
Албан салбарт	85.0	44.9	40.1	82.4	49.3	33.1
Албан бус салбарт	383.9	222.2	161.7	395.2	232.9	162.3
Өрхийн нэгжид	7.2	3.7	3.5	3.8	2.1	1.7
<b>БҮГД, ХАА-Н БУС САЛБАР</b>	<b>195.2</b>	<b>113.6</b>	<b>81.6</b>	<b>209.9</b>	<b>133.5</b>	<b>76.4</b>
Албан салбарт	82.5	43.0	39.5	79.8	47.4	32.4
Албан бус салбарт	110.2	69.4	40.8	126.7	84.4	42.3
Өрхийн нэгжид	2.5	1.2	1.3	3.4	1.7	1.7

## АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 2020 оны**  
12 сарын эцэст




Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, 2020 оны эцэст




## 2.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Манай улсын хувьд ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэдийн статистикийн мэдээллийг цуглуулах ажлыг тодорхой үе шаттайгаар шинэчлэн боловсруулж ирснийг дор харууллаа.



Энэхүү мэдээллийг батлагдсан маягт, зааврын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сар бүр хүлээн авч, нягтлан шалгаж, бүртгэлтэй ажилгүй иргэд, шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн зэрэг үзүүлэлтүүдийг сар, жилийн бюллетень, танилцуулга болон статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn) сайтад байршуулан нийтэд тархааж байна.

### МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН СХЕМ



## 2.2. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны эцэст 29.9 мянга, үүнээс 18.1 (60.5%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11.8 (39.5%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

### ЗУРАГ 2.1. АЖИЛ ХАЙЖ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД, ТӨРӨЛ




Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил хайж бүртгүүлсэн иргэдийн 56.3 хувь нь 15-34 насны залуучууд эзэлж байгаа ба энэ үзүүлэлт Дорнод, Өмнөговь, Баянхонгор аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 1.2-6.5 пунктээр илүү байна. Ажил хайж бүртгүүлсэн иргэд 2014-2020 оны дунджаар 42.8 мянга байгаагийн 22.6 (52.8%) мянга нь эмэгтэй байна.

Ажил хайгч иргэдийн 0.9 хувийг магистр, доктор, 21.6 хувийг дипломын болон бакалаврын, 3.7 хувийг тусгай мэргэжлийн дунд, 5.0 хувийг техникийн болон мэргэжлийн, 58.8 хувийг бүрэн дунд, 6.4 хувийг суурь, 2.1 бага боловсролтой, 1.5 боловсролгүй иргэд эзэлж байна.

Бүрэн дунд боловсролтой ажил хайгч иргэд 2014 онд 45.6 хувийг эзэлж байсан бол энэ үзүүлэлт нэмэгдсээр 2019 онд 59.6 хувь болж нийт ажил хайж бүртгүүлсэн иргэдийн талаас илүү хувийг эзэлж байна.

### ЗУРАГ 2.2. АЖИЛ ХАЙЖ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажиллах хүчний судалгааны 2020 оны дүнгээр улсын хэмжээнд 127.7 мянган ажилгүй иргэд байна. Эдгээрээс хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэд 2020 оны эцэст 18.1 мянга болсны 9.5 мянга нь эмэгтэйчүүд байна.

### ХҮСНЭГТ 2.1. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХӨДӨЛГӨӨНӨӨР, МЯНГАН ХҮНЭЭР


Үзүүлэлт	2011	2010	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүртгэлтэй ажилгүй иргэд	57.2	38.3	35.8	42.8	37.0	32.8	34.4	25.5	25.0	20.8	18.1
Шинээр бүртгүүлсэн иргэд	77.7	64.3	61.5	110.1	109.7	122.8	117.1	93.3	93.5	87.0	68.1
Ажилд зуучлагдан орсон иргэд	97.4	46.3	32.3	65.9	27.4	27.7	21.0	28.6	25.6	27.2	19.3
Ажил хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд	15.0	17.8	47.6	37.2	89.8	99.3	94.4	73.7	68.4	64.0	51.5

*Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 онд жилд давхардсан тоогоор ажилгүй 68.1 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 19.3 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 51.5 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь 2010 оныхтой харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 3.8 хувиар өссөн бол ажилд зуучлагдан орсон иргэд 27.0 хувиар буурсан байна. Харин ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 33.7 дахин нэмэгджээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистикийн мэдээллээр аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2020 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 30.0 мянга болжээ. Үүнээс 18.1 (60.4%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11.9 (39.6%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

### ЗУРАГ 2.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД АЖИЛ ХАЙЖ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД, САРААР



*Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*

Улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 4.3 (42.8%) мянган хүн, ажилд зуучлагдан орсон иргэд 2.4 (50.3%) мянган хүн, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 1.9 (32.3%) мянган хүнээр буурчээ.


#### ЗУРАГ 2.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, САРААР



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

2020 оны байдлаар нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.8 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байгаа бол энэ нь 2010 оныхоос 4.2 пункт, 2015 оныхоос 7.5 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

#### ЗУРАГ 2.5. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




Тайлбар \*- Насны ангилал өөрчлөгдсөн

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 12 дугаар сард 5.8 мянган хүн шинээр бүртгүүлсний 3.2 (54.6%) мянга нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байгаа нь өмнөх сараас 400 (11.2%) хүнээр буурчээ.


ЗУРАГ 2.6. ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, АЖИЛ ХАЙЖ БУЙ ШАЛТГААНААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОНЫ ЭЦЭСТ



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажилд зуучлагдан орсон иргэдийн 78.6 хувийг 15-34 насны иргэд эзэлж байгаа бол 56.2 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.


ЗУРАГ 2.7. АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ХҮН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОНЫ ЭЦЭСТ



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам




ЗУРАГ 2.8. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам


Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 293 (1.6%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 152 (51.8%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 2.9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХҮЙСЭЭР



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧ



### 3.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системийн мэдээллийг Үндэсний статистикийн хороонд ирүүлж Үндэсний статистикийн хороо нь албан ёсны статистик болгон тархааж байна.

#### МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН СХЕМ



Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системийн мэдээллийг Үндэсний статистикийн хороонд ирүүлж ҮСХороо нь албан ёсны статистик болгон тархааж байна.

Танилцуулгад төрийн нийт албан хаагч, үүнээс төрийн улс төрийн, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийг байршил, албан тушаалын ангилал, боловсрол, нас, хүйс, бүрэлдэхүүн, хөдөлгөөний үндэслэл шалтгааны гол гол үзүүлэлтүүдийг авч график болон хүснэгтэн хэлбэрээр тусгасан болно. Харин Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн төрийн тусгай албан хаагчдын зарим тоон мэдээллийг нэгдсэн дүн мэдээнд хамруулаагүй болно.

Тайлант онд төрийн 4147 байгууллагад 205011 төрийн албан хаагч ажиллажээ. Төрийн албан хаагчдын тоо өнгөрсөн оноос 6548 буюу 3.3 хувиар нэмэгджээ. Үүний дотор төрийн захиргааны албан хаагчийн тоо 1473 хүнээр, төрийн улс төрийн албан хаагчийн тоо 34 хүнээр, тус тус өссөн байна.

Үндэсний үнэт зүйл, өв соёлоо дээдлэх, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг үүрэг бүхий Соёлын яам, худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай зохион байгуулах чиг үүрэгтэй Төрийн худалдан авах ажиллагааны газар, усны нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Усны газар, уул уурхай, геологи, геофизик, геохимийн судалгаа шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Үндэсний геологийн алба, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Жижиг, дунд үйлдвэрийн газар болон нийслэлийн 2 агентлаг, дүүргүүдийн 21 хороо “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд шинээр бүртгүүлсэн нь тооны өсөлтөд нөлөөлжээ.


Онцгой байдлын анги, салбар, бүлэг, бүтээн байгуулалтад оролцох инженерийн болон тусгай мэргэжилтэй цэргийн албан хаагчид нэмэгдсэн, экологийн цагдаагийн алба байгуулагдсан, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлийн болон нийслэлийн зарим хорооны цагдаагийн алба зэрэг байгууллагыг бэхжүүлсэнтэй холбоотойгоор төрийн тусгай албан хаагчийн тоо өссөн байна.

Төрийн үйлчилгээний албан хаагчийн тоо 1845-аар буурчээ. Энэ нь өмнөх оны тайланд хамрагдсан төрийн байгууллагуудаас төрийн өмчит их, дээд сургууль, түүний бүрэлдэхүүн сургууль, УТҮГ, ТӨҮГ, ОНӨҮГ-ыг хамруулаагүй нь эдгээр байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, тэдний хөдөлмөрийн харилцаатай холбоотой бусад асуудлыг салбарын хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулсантай холбоотой юм. Тухайлбал: Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-ийг баталсныг үндэслэн төрийн өмчийн их, дээд сургуулийн удирдлага, багш, ажилтныг хамруулаагүй болно.


### 3.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Төрийн албан хаагчид 2020 оны эцэст 205.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 6.5 (3.3%) мянгаар өссөн байна. Төрийн албан хаагчдыг төрийн албаны ангиллаар авч үзэхэд 2020 онд өмнөх оноос төрийн тусгай албан хаагчид 6.9 (17.9%) мянга, төрийн захиргааны албан хаагчид 1.5 (7.7%) мянга, төрийн улс төрийн албан хаагчид 34 (0.9%) хүнээр өссөн бол төрийн үйлчилгээний албан хаагчид 1.8 (1.3%) мянгаар буурсан байна.

#### ЗУРАГ 3.1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, АНГИЛЛААР



#### ЗУРАГ 3.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ АЛБАН ТУШААЛЫН ТӨРЛӨӨР




Төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан хаагчдыг албан тушаалын төрлөөр нь ангилж үзвэл 113.5 (71.1%) мянга нь гүйцэтгэх албан тушаалтан, 34.9 (21.9%) мянга нь туслах албан тушаалтан, 11.2 (7.0%) мянга нь удирдах албан тушаалтан байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн төрийн тусгай албан хаагчдын мэдээллийг хамруулаагүй болно.

#### ЗУРАГ 3.3. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, ХҮНЭЭР




Нийт төрийн албан хаагчдыг боловсролын түвшнээр авч үзэхэд 109.6 (53.5%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 33.9 (16.6%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 31.4 (15.3%) мянга нь бүрэн дунд, 18.1 (8.8%) мянга нь магистр болон доктор, 8.9 (4.3%) мянга нь суурь, 1.4 (0.7%) мянга нь тусгай мэргэжлийн дунд, 1.6 мянга (0.8%) бага болон түүнээс доош боловсролтой байна.

ЗУРАГ 3.4. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, БАЙРШЛААР




Төрийн албан хаагчдаас 102.2 (49.8%) мянга нь нутгийн захиргааны байгууллага, түүний харьяа байгууллагуудад, 98.4 (48.1%) мянга нь нийслэлийн захиргааны байгууллага, түүний харьяа байгууллагуудад, 4.4 (2.1%) мянга нь төрийн төв байгууллага, түүний харьяа байгууллагуудад тус тус ажиллаж байна.

ЗУРАГ 3.5. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, НАСНЫ БҮЛГЭЭР




Төрийн албан хаагчдыг насны бүлгээр авч үзэхэд 25 хүртэлх насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд) 9.3 хувь, 26-аас 55 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан) 85.2 хувь, 55-аас дээш насныхан 5.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.6. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ДУНДАЖ НАСНЫ ӨӨРЧЛӨЛТ (СҮҮЛИЙН 10 ЖИЛЭЭР)




Төрийн албанд ажиллагсдын дундаж нас 40,05 болж өмнөх оноос 1,66 жилээр нэмэгджээ. Энэ нь төрийн албаны мерит зарчмын дагуу туршлага, ур чадвар бүхий албан хаагчид төрийн албанд тогтвор, суурьшилтай ажиллаж байгааг илэрхийлсэн эерэг үзүүлэлт юм.

## ЗУРАГ 3.7. ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ХҮЙСЭЭР



Төрийн захиргааны албан хаагчдын 0.1 (0.6%) мянга нь тэргүүн түшмэл, 0.7 (3.4%) мянга нь эрхэлсэн түшмэл, 2.3 (11.2%) мянга нь ахлах түшмэл, 14.2 (69.1%) мянга нь дэс түшмэл, 3.2 (15.7%) мянга нь туслах түшмэлийн албан тушаалтай байна.

## ЗУРАГ 3.8. ТӨРИЙН АЛБАНД АЖИЛЛАГЧДЫН ТОО, САЛБАРААР



Төрийн албанд ажиллагчдын 49.5 (24.1%) мянга нь ерөнхий боловсролын салбарт, 41.9 (20.4%) мянга нь төрийн тусгай чиг үүргийн байгууллагад, 30.3 (14.8%) мянга нь эрүүл мэндийн салбарт, 26.2 (12.8%) мянга нь сургуулийн өмнөх боловсролын салбарт, 15.5 (7.4%) мянга нь яам, агентлагт, 10.3 (5.0%) мянга нь аймаг, сумын засаг даргын тамгын газарт, 6.1 (3.0%) мянга нь соёл урлагийн салбарт тус тус ажиллаж байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.

## МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БУЙ АЖИЛЛАГЧ

**4 039**

Гадаад  
ажиллагчид

**3 472**

Эрэгтэй  
ажиллагчид

**567**

Эмэгтэй  
ажиллагчид

### Улс, орноор



**БНХАУ**  
51.2%



**ОХУ**  
6.4%



**БНСУ**  
5.3%




**Австрали**  
5.0%



**АНУ**  
3.7%


### Насны бүлгээр



### Цалин, хөлс

240 мян.төг хүртэлх	13.7%
240 мян-1.1 сая төг	34.2%
1.1-10 сая төг	37.4%
10 сая төг дээш	14.7%

### Ажиллаж буй бүс, нутгаар



### Үйл ажиллагааны салбараар





#### 4.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Монгол улсад хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэдийн статистикийн улирал тутам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллийн эх үүсвэртэйгээр тархааж байна.

##### МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН СХЕМ




Уг мэдээний анхан шатны бүртгэл нь ажил олгогч, аж ахуй нэгж, байгууллагууд 11 төрлийн бүрдүүлэх материалыг гадаадаас хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар уригдсан ажиллагч, мэргэжилтэн тус бүрээр болон ААНБ-ын хувьд бүрдүүлж ХХҮЕГ-т ирүүлдэг. Нэгдсэн мэдээллийн санг тэдгээр материалууд дээр үндэслэн баяжуулж, бүртгэл хөтөлдөг.

**Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо /Өссөн дүнгээр/:** Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаадын иргэнд

- (1) урьдчилсан зөвшөөрөл /урилга/ олгох
- (2) хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох
- (3) зөвшөөрлийн хугацааг сунгах
- (4) цуцлах

Тухайн тайлант хугацааны эцэст Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо /Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу идэвхтэй/



Тодруулбал, гадаадаас хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллахаар уригдсан иргэн тус бүр болон тухайн ажиллах хүч авагч байгууллагын хувьд эдгээр бүрдүүлэх материалуудыг нэг бүрчлэн бүрдүүлэн авчирч танилцуулахыг шаарддаг юм. Эдгээр 11 төрлийн бүрдүүлэх материалуудад 4 төрлийн анхан шатны маягт байдаг ба түүнийг хүн тус бүрээр бөглөн бүртгүүлдэг. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаад ажиллагчдад цалин, орлого олох зорилготой ажиллагчдаас гадна цалин, орлого олох зорилгогүй сайн дурын үйл ажиллагаа эрхэлж буй иргэд багтсан байдаг.

## 4.2. МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА ГАДААД ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Манай улсад 2020 оны байдлаар гадаадын 4.0 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна. Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 1.5 (36.7%) мянга нь уул уурхай, олборлолтын, 688 (17.0%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 610 (15.1%) нь боловсролын, 483 (12.0%) нь барилгын, 322 (8.0%) нь боловсруулах үйлдвэрлэлийн, 166 (4.1%) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 120 (3.0%) нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны, 0.2 (4.1%) мянга нь бусад салбарт ажиллаж байна.

### ХҮСНЭГТ 4.1. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛААР

Салбар	2016	2017	2018	2019	2020
Бүгд	5 938	4 703	4 502	4 601	4 039
Уул уурхай, олборлолт	1 968	1 753	1 654	1 762	1 481
Боловсруулах үйлдвэрлэл	768	339	295	267	322
Барилга	963	363	121	197	483
Бөөний болон жижиглэн худалдаа, Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	612	649	782	759	688
Боловсрол	94	100	121	151	166
Бусад	924	882	918	990	610
Бусад	609	617	611	475	289

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

### ЗУРАГ 4.1 ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛААР, ХУВИАР



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам


Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй нийт гадаадын иргэдийн 51.2 хувь нь БНХАУ-ын, 6.4 хувь нь ОХУ-ын, 5.3 хувь нь БНСУ-ын, 5.0 хувь нь Австрали Улсын, 3.7 хувь нь АНУ-ын, 3.3 хувь нь Өмнөд Африк Улсын, 2.9 хувь нь Филиппин Улсын, 2.6 хувь нь Вьетнам Улсын, 2.5 хувь нь Их британи Улсын, 2.0 хувь нь Канад Улсын, 2.0 хувь нь БНЭУ-ын, 1.2 хувь нь Япон Улсын, 11.9 хувь нь бусад улсын харьяат байна. Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 3.5 (86.0%) мянга нь эрэгтэй, 0.5 (14.0%) мянга нь эмэгтэй байна.

## ХҮСНЭГТ 4.2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, УЛС ОРНООР

Улс орон	2016		2017		2018		2019		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүн	5 938	894	4 703	782	4 502	754	4 601	805	4 039	567
Австрали	288	37	334	30	472	39	407	31	202	9
Англи	96	14	115	19	148	24	128	18	100	16
АНУ	264	76	254	74	265	73	246	68	151	39
Вьетнам	148	-	198	1	243	2	199	2	104	-
Казахстан	68	20	47	18	42	16	44	17	38	15
Канад	172	17	170	17	149	14	120	13	80	12
ОХУ	477	176	343	167	300	143	325	175	258	137
Өмнөд Африк	86	7	117	6	144	3	162	1	133	2
БНСУ	355	87	305	88	273	77	280	80	214	51
БНАСАУ	1 177	116	340	19	-	-	-	-	-	-
Турк	72	12	59	9	28	5	48	1	20	1
Филиппин	102	28	93	36	150	62	168	88	116	62
БНХАУ	2 045	187	1 762	185	1 648	178	1 665	185	2 069	115
Энэтхэг	79	9	78	7	88	6	87	11	79	12
Япон	112	27	111	30	109	26	94	23	48	15
Бусад	397	81	377	76	443	86	628	92	427	81

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам


## ЗУРАГ 4.2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, УЛС ОРНООР, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил эрхэлж буй гадаадын иргэдийг насны бүлгээр авч үзэхэд 1.9 хувь нь 20-24 насных, 7.0 хувь нь 25-29 насных, 12.5 хувь нь 30-34 насных, 14.6 хувь нь 35-39 насных, 14.3 хувь нь 40-44 насных, хамгийн их буюу 18.7 хувь нь 45-49 насны иргэд, хамгийн бага буюу 0.02 хувь нь 20 хүртэлх насных байна.

## ЗУРАГ 4.3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛГЭЭР, ЭЗЛЭХ ХУВИАР



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 1.7 (41.3%) мянга нь Улаанбаатарт, 1.2 (29.0%) мянга нь Төвийн бүсэд, 0.7 (18.9%) мянга нь Зүүн бүсэд, 0.3 (8.8%) мянга нь Хангайн бүсэд, 0.1 (2.0%) мянга нь Баруун бүсэд ажиллаж байна.


## ХҮСНЭГТ 4.3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ОНЫ ЭЦЭСТ, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР

Аймаг, нийслэл	2016	2017	2018	2019	2020
Дүн	5 938	4 703	4 502	4 601	4 039
Баруун бүс	120	66	68	90	85
Баян-Өлгий	17	15	10	13	31
Говь-Алтай	35	3	9	27	12
Завхан	5	4	5	10	8
Увс	1	2	1	1	3
Ховд	62	42	43	39	31
Хангайн бүс	503	329	257	303	354
Архангай	5	1	-	1	-
Баянхонгор	14	8	4	6	16
Булган	1	1	2	12	9
Орхон	478	286	245	279	326
Өвөрхангай	3	31	4	2	-
Хөвсгөл	2	2	2	3	3
Төвийн бүс	1 077	1 144	1 487	1 307	1 170
Говьсүмбэр	10	3	3	3	11
Дархан-Уул	54	65	122	48	62
Дорноговь	243	212	106	120	242
Дундговь	11	3	6	9	11
Өмнөговь	615	794	1 190	1 063	693
Сэлэнгэ	17	16	9	6	83
Төв	127	51	51	58	68
Зүүн бүс	1 272	909	695	793	763
Дорнод	1 083	843	622	706	609
Сүхбаатар	134	53	54	66	132
Хэнтий	55	13	19	21	22
Улаанбаатар	2 966	2 255	1 995	2 108	1 667

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2.1 (50.9%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 1.2 (30.0%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 0.4 (10.1%) мянга нь бүрэн дунд, 0.2 (6.1%) мянга нь тусгай мэргэжлийн дунд, 0.1 (2.9%) мянга нь суурь боловсролтой байна.


#### ЗУРАГ 4.4. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



*Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд хамгийн их буюу 1.7 (41.0%) мянга нь мэргэжилтэн, хамгийн бага буюу 2 (0.05%) иргэн хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн мэргэжлээр ажиллаж байна. Байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 3.0 (74.0%) мянга нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 0.5 (12.7%) мянга нь төсөвт байгууллагад, 0.1 (2.8%) мянга нь төрийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газарт, 98 (2.4%) нь төрийн бус байгууллагад, 0.3 (8.1%) мянга нь бусад байгууллагад ажиллаж байна.

## ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН



Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбарт




Хамтын маргаанд хамрагдсан ажиллагчид **107**, үүнээс **26** нь эмэгтэй ажиллагчид

## 5.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ДАВТАМЖ, УРСГАЛ

Хөдөлмөрийн хамтын маргааны тоо мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагууд аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэст, ХХҮХэлтэс нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, ХНХяам нь Үндэсний статистикийн хороонд ирүүлж ҮСХ-ноос албан ёсны статистик болон тархаагдаж байна.

### МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН СХЕМ



## 5.2. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНЫ СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн хамтын маргаан 2020 онд 1 бүртгэгдэж өмнөх оноос 1 (50.0%)-ээр буурсан байна. Харин нийт хөдөлмөрийн маргаанд хамрагдсан ажиллагчид өмнөх оноос 2 (1.8%)-оор буурсан байна.

### ХҮСНЭГТ 5.1. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Хамтын маргааны тоо	239	90	2	1
Хамрагдсан ажиллагчид	5 924	6 375	109	107
Ажлын нэг өдөр түүнээс дээш хугацаатай ажил хаялт	5 717	5 007	-	-
Ажлын байр түр хаалт	3	-	-	-
Бусад хэлбэр	204	47	-	-
1000 ажиллагчид ногдох хамрагдсан ажиллагчид	4.8	5.1	0.1	0.1

*Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*

2020 оны байдлаар хөдөлмөрийн маргаанд хамрагдагч 107 (100.0%) ажиллагчид нь цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарынх байна.

### ХҮСНЭГТ 5.2. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНД ХАМРАГДАГЧИД, САЛБАРААР

Үйл ажиллагааны чиглэл	2017		2018		2019		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	126	80	-	-	-	-	-	-
Уул уурхай, олборлолт	238	11	-	-	-	-	-	-
Боловсруулах үйлдвэрлэл	-	-	139	80	-	-	-	-
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	-	-	-	-	-	-	107	26
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	-	-	-	-	77	24	-	-
Боловсрол	6210	4854	6236	5157	32	26	-	-
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>6574</b>	<b>4945</b>	<b>6375</b>	<b>5237</b>	<b>109</b>	<b>50</b>	<b>107</b>	<b>26</b>

*Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*

## ХҮСНЭГТ 5.3. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНД ХАМРАГДСАН АЖИЛЛАГЧИД, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР


Аймаг, нийслэл, бүс	2017		2018		2019		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Баруун бүс	-	-	-	-	-	-	107	26
Баян-Өлгий	-	-	-	-	-	-	-	-
Говь-Алтай	-	-	-	-	-	-	-	-
Завхан	-	-	-	-	-	-	-	-
Увс	-	-	-	-	-	-	-	-
Ховд	-	-	-	-	-	-	107	26
Хангайн бүс	927	658	1002	767	77	24	-	-
Архангай	-	-	-	-	77	24	-	-
Баянхонгор	775	534	-	-	-	-	-	-
Булган	70	62	-	-	-	-	-	-
Орхон	-	-	1002	767	-	-	-	-
Өвөрхангай	82	62	-	-	-	-	-	-
Хөвсгөл	-	-	-	-	-	-	-	-
Төвийн бүс	355	331	1021	893	-	-	-	-
Говьсүмбэр	-	-	-	-	-	-	-	-
Дархан-Уул	273	256	284	261	-	-	-	-
Дорноговь	-	-	531	447	-	-	-	-
Дундговь	-	-	-	-	-	-	-	-
Өмнөговь	-	-	-	-	-	-	-	-
Сэлэнгэ	82	75	206	185	-	-	-	-
Төв	-	-	-	-	-	-	-	-
Зүүн бүс	831	461	261	204	32	26	-	-
Дорнод	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	831	461	261	204	32	26	-	-
Хэнтий	-	-	-	-	-	-	-	-
Улаанбаатар	3811	2669	2801	2323	-	-	-	-
УЛСЫН ДҮН	5924	4119	5085	4187	109	50	107	26

*Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам*

Хөдөлмөрийн хамтын маргаанд 2020 онд Ховд аймагт нийт 107 ажиллагчид хамрагдсан байна. Харин 2019 онд хамтын маргаанд 2 ажиллагчид хамрагдсан нь өмнөх оноос 4976 буюу 97.9 хувиар буурсан байна.

2017 онд нийт 239 хөдөлмөрийн хамтын маргаан бүртгэгдсэнийг шийдвэрлэсэн байдлаар нь үзвэл 238 буюу 99.6%-ийг шийдвэрлэсэн бол 2018 онд 90 хамтын маргаан бүртгэгдсэнээс 89 буюу 98.9%-ыг шийдвэрлэсэн байна. Харин 2020 онд 1 хамтын маргаан бүртгэгдсэн ч шийдвэрлээгүй байна.

## ЗУРАГ 5.1. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН, ШИЙДЭГДСЭН БАЙДЛААР





## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО



### 6.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Үндэсний статистикийн хороо нь Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллийн эх үүсвэрээс улирлын давтамжтайгаар албан ёсны статистик болгон тархааж байна.

Анхан шатны бүртгэл нь, ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай бүр “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийн маягт”-ын дагуу мэдээллийг бүртгэж тухайн орон нутгийн мэргэжлийн хяналтын газарт ажлын 3 хоногийн дотор хүргүүлж, орон нутгийн мэргэжлийн хяналтын газар ажил олгогчоос ирүүлсэн мэдээллийг нэгтгэн [www.om.inspection.gov.mn](http://www.om.inspection.gov.mn) сайтад мэдээллийг шивж онлайнаар МХЕГ-т дамжуулснаар бүрддэг.

Судлан  
бүртгэх дүрэм

“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ны 269 дугаар тогтоолоор баталсан бөгөөд хуучин дүрмийн хавсралт болох “Үйлдвэрлэлийн ослын хагас, бүтэн жилийн тайлангийн маягт”-ыг албан ёсны болон захиргааны статистик мэдээ, тайлангийн маягт болгон, мөрдүүлэх шийдвэрийг гаргасан.

Маягт, заавар

Аргачлал,  
арга зүй

ҮСХ нь Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын статистикийг бий болгох үүднээс 2015 оны 11 дүгээр сарын 24-ны А/134 тоот тушаалаар мэдээллийн маягт, зааврыг батлан 2016 оноос мөрдөж эхлээд байгаа.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ны А/185 тоот тушаалаар батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан гэмтлийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг үндсэн аргачлал болгон мөрдөнө.

#### МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН СХЕМ



## 6.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2020 онд 353 бүртгэгдсэнээс 345 (97.7%) нь үйлдвэрлэлийн осол, 8 (2.3%) нь хурц хордлого байна.

Нийт осолдогчдыг бүсээр нь авч үзвэл Баруун бүс 34(9.6%), Хангайн бүс 44(12.5%), Төвийн бүс 88 (24.9%), Төв аймаг 22 (6.2%), Өмнөговь аймаг 21 (5.9%), Зүүн бүс 28 (7.9%), Улаанбаатар хотод 139 (39.4%), 20 (5.7%) бусад газар бүртгэгдсэн байна. Мөн 2020 онд хурц хордлого 8 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Улаанбаатар хот Хан-Уул дүүрэгт 2, Дархан-Уул аймагт 3, Баян-Өлгий аймагт 1, Бусад салбарт 2 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг өмнөх жилтэй харьцуулахад 5.1 хувиар нэмэгдсэн байна.

### ХҮСНЭГТ 6.1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧ АЙМАГ, НИЙСЛЭЛ, БҮСЭЭР, 2016-2020 ОН


Аймаг	2016	2017	2018	2019	2020	2020 2019	
						Тоо	Хувь
Дүн	332	332	283	336	353	17	5.1
Баруун бүс	30	28	31	29	34	5	17.2
Баян-Өлгий	8	4	4	4	5	1	25.0
Говь-Алтай	5	3	7	13	5	-8	-61.5
Завхан	11	7	4	6	12	6	100.0
Увс	3	4	-	3	3	-	-
Ховд	3	10	16	3	9	6	200.0
Хангайн бүс	43	24	30	39	44	5	12.8
Архангай	3	5	6	3	1	-2	-66.7
Баянхонгор	10	1	4	11	9	-2	-18.2
Булган	2	1	4	2	3	1	50.0
Орхон	20	11	15	19	19	-	-
Өвөрхангай	4	3	1	3	3	-	-
Хөвсгөл	4	3	-	1	9	8	800.0
Төвийн бүс	70	105	86	93	88	-5	-5.4
Говьсүмбэр	5	6	6	6	6	-	-
Дархан-Уул	21	48	14	10	19	9	90.0
Дорноговь	3	2	8	16	8	-8	-50.0
Дундговь	3	3	3	4	3	-1	-25.0
Өмнөговь	15	26	23	33	21	-12	-36.4
Сэлэнгэ	12	10	16	11	9	-2	-18.2
Төв	11	10	16	13	22	9	69.2
Зүүн бүс	30	27	34	35	28	-7	-20.0
Дорнод	6	5	17	13	15	2	15.4
Сүхбаатар	6	6	1	5	4	-1	-20.0
Хэнтий	18	16	16	17	9	-8	-47.1
Улаанбаатар	146	135	94	124	139	15	12.1
Бусад <sup>1</sup>	13	13	8	16	20	4	25.0

<sup>1</sup> Цахилгаан станцууд болон Улаанбаатар төмөр замд гарсан үйлдвэрлэлийн ослыг оруулсан.

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоог хүйсээр нь авч үзвэл 2020 онд 268 (75.9%) нь эрэгтэй ажиллагч, 85 (24.1%) нь эмэгтэй ажиллагч байна. 2016-2020 онуудад 1160 (70.9%) нь эрэгтэй ажиллагчид, 476 (29.1%) нь эмэгтэй ажиллагчид тус бүр осолд өртсөн байна.

ЗУРАГ 6.1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, ХҮЙСЭЭР, 2016-2020 ОН



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар


ХҮСНЭГТ 6.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2016-2020 ОН

Насны бүлэг	2016		2017		2018		2019		2020	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	332	115	332	105	283	83	336	88	353	85
18 хүртэлх	2	-	2	1	2	-	6	1	2	-
18-24 насных	27	4	22	6	34	9	47	5	46	7
25-34 насных	118	28	114	27	95	12	113	21	143	18
35-44 насных	70	24	84	20	71	26	94	29	89	28
45-59 насных	110	56	108	50	77	34	75	32	68	31
60 ба түүнээс дээш	5	3	2	1	4	2	1	-	5	1

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Осолдогчдыг насны бүлгээр нь авч үзэхэд 15-17 насных 2 (0.6%), 18-24 насных 46 (13%), 25-34 насных 143 (40.5%), 35-44 насных 89 (25.2%), 45-59 насных 68 (19.3%), 60 ба түүнээс дээш насных 5 (1.4%) байна. Тоон мэдээллээс үзэхэд 25 дээш насны хүмүүс осолд өртөх тохиолдол нь ихсэж байна.

ЗУРАГ 6.2. ОСОЛДОГЧИД, НАСНЫ БҮЛГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдогчдыг хэлбэрээр нь авч үзвэл 2020 онд 143 (40.5%) нь хөнгөн хэлбэрийн гэмтэл авсан бөгөөд 29 (20.3%) нь уул уурхай, олборлолтын салбарт, 26 (18.2%) нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт, 15 (10.5%) нь тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарт гэмтэл авсан байна.

Харин хүнд гэмтлээр 170 (48.2) хүн осолдсоноос 37 (21.8%) нь уул уурхай, олборлолтын салбарт, 25 (14.7%) нь тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарт, 22 (12.9%) нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт гэмтэл авсан байна.


### ХҮСНЭГТ 6.3. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД ХЭЛБЭР, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР 2016-2020 ОН

Салбар	Хөнгөн					Хүнд				
	2016	2017	2018	2019	2020	2016	2017	2018	2019	2020
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	1	3	1	1	3	1	2	2	5
Уул уурхай, олборлолт	21	24	30	27	29	37	24	31	34	37
Боловсруулах үйлдвэрлэл	8	10	12	7	15	20	48	13	13	19
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7	2	2	6	1	10	3	2	3	3
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1	7	2	4	3	3	4	6	12	1
Барилга	7	2	1	10	14	7	7	12	19	19
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3	2	1	5	5	5	3	5	3	3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	12	10	12	25	15	5	8	12	12	25
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2	1	3	9	2	3	3	1	2	1
Мэдээлэл, холбоо	4	1	1	3	1	3	3	2	1	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5	8	3	3	5	2	4	4	7	1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	-	-	-	1	-	-	1	-	2	3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1	1	1	-	-	2	1	3	-	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	17	12	13	8	26	19	22	18	11	22
Боловсрол	19	10	4	5	5	14	22	11	8	8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	20	17	10	9	13	15	18	15	7	10
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	-	-	1	-	-	1	1	-	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12	11	7	14	8	9	11	8	10	12
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	1	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1	1	1	-	-	2	1	-	-	-
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>142</b>	<b>120</b>	<b>106</b>	<b>138</b>	<b>143</b>	<b>159</b>	<b>185</b>	<b>147</b>	<b>146</b>	<b>170</b>

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар


Осолдогчдын 40 (11.3%) хүн нас барсан бөгөөд ихэнх нь 7 (17.5%) нь уул уурхай, олборлолтын салбарт, 10 (25%) нь барилгын салбарт, 5 (12.5%) нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт гарсан ослын улмаас нас барсан байна. 2020 онд 100.000 хүн ам тутмын 3 нь нас барж, 27 нь хөнгөн болон хүндээр гэмтсэн байна.

ЗУРАГ 6.3. АЖЛЫН БАЙР ДАХЬ ХҮНД БОЛОН ХӨНГӨН ОСОЛ ГЭМТЛИЙН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН (100.000 АЖИЛЛАГЧ ТУТАМД)



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

ЗУРАГ 6.4. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД ХЭЛБЭР, ЭЗҮА-НЫ САЛБАРААР, САЛБАРЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

**ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР**

Үйлдвэрлэлийн осолдогчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл 2020 онд уул уурхай, олборлолт, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбаруудын үйлдвэрлэлийн осол хурц, хордлогоор осолдогчийн дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа бол хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар осолдогчийн ихэнх нь эмэгтэйчүүд байна.

Уул уурхай, олборлолтын салбарт улсын дүнгээр 73 (20.7%), эрэгтэй ажиллагсад 67 (91.8%), эмэгтэй ажиллагсад 6 (8.2%), Барилгын салбарт 43 (12.2%), эрэгтэй ажиллагсад 41 (95.3%), эмэгтэй ажиллагсад 2 (4.7%), тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 44 (12.5%), эрэгтэй ажиллагсад 36 (81.8%), эмэгтэй ажиллагсад 8 (18.2%), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 53 (15%), эрэгтэй ажиллагсад 46 (86.8%), эмэгтэй ажиллагсад 7 (13.2%), Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа салбарт улсын дүн 24 (6.8%), эрэгтэй ажиллагсад 4 (16.7%), эмэгтэй ажиллагсад 20 (83.3%) байна.

**ХҮСНЭГТ 6.4. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР 2016-2020 ОН**

Салбар	2016		2017		2018		2019		2020						
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй			
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5	4	1	2	2	-	6	5	1	3	3	-	6	2	4
Уул уурхай, олборлолт	61	52	9	55	51	4	73	66	7	80	78	2	73	67	6
Боловсруулах үйлдвэрлэл	32	26	6	62	53	9	26	14	12	24	20	4	36	28	8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт усан хангамж, боохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	5	5	-	11	8	3	9	6	3	23	20	3	5	5	-
болон шэвэрлэх үйл ажиллагаа Барилга	21	19	2	15	12	3	17	16	1	38	33	5	43	41	2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар	8	7	1	5	3	2	7	5	2	8	6	2	8	3	5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	19	16	3	21	16	5	27	25	2	39	31	8	44	36	8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	5	1	4	4	2	2	4	2	2	11	4	7	3	0	3
Мэдээлэл, холбоо	8	5	3	4	2	2	3	3	-	5	4	1	4	3	1
Санхүүгийн болон даатгалын үйл	7	2	5	13	4	9	7	2	5	10	7	3	6	3	3
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	-	-	-	2	2	-	-	-	-	3	1	2	3	3	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3	3	-	2	1	1	4	2	2	-	-	-	-	-	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан	43	25	18	36	27	9	34	19	15	22	13	9	53	46	7
Боловсрол	33	15	18	32	12	20	16	9	7	14	1	13	14	6	8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	36	10	26	35	11	24	25	5	20	16	1	15	24	4	20
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	-	1	1	1	-	1	0	1	1	1	-	1	1	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23	13	10	24	16	8	15	13	2	27	13	14	23	13	10
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	-	-	1	-	1	1	1	-	-	-	-	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	3	-	3	2	1	1	1	-	1	-	-	-	-	-	-
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>332</b>	<b>217</b>	<b>115</b>	<b>332</b>	<b>227</b>	<b>105</b>	<b>283</b>	<b>200</b>	<b>83</b>	<b>336</b>	<b>248</b>	<b>88</b>	<b>353</b>	<b>268</b>	<b>85</b>

*Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар*

**АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР**

Осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр авч үзвэл 2020 онд энгийн ажил мэргэжилтэй 100 (28.3%), үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан 63 (17.8%), суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч 53 (15%), зэвсэгт хүчний ажил, мэргэжил 38 (10.8%), мэргэжилтэн 29 (8.2%), техникч болон туслах, дэд мэргэжилтэн 22 (6.2%), контор, үйлчилгээний ажилтан 20 (5.7%), худалдаа, үйлчилгээний ажилтан 12 (3.4%), менежер 10 (2.8%), ХАА, ой, загас агнуурын ажилтан 6 (1.7%) тус тус эзэлж байна.


## ХҮСНЭГТ 6.5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР

Ажил мэргэжлийн ангилал	2016	2017	2018	2019	2020
Бүгд	332	332	283	336	353
Менежер	9	7	5	8	10
Мэргэжилтэн	46	48	54	30	29
Техникч болон туслах, дэд мэргэжилтэн	33	28	25	26	22
Контор, үйлчилгээний ажилтан	21	21	18	16	20
Худалдаа, үйлчилгээний ажилтан	8	2	4	9	12
ХАА, ой, загас агнуурын ажилтан	2	-	1	-	6
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	43	26	37	51	63
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	36	72	38	45	53
Энгийн ажил, мэргэжил	111	105	91	142	100
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	23	23	10	9	38

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

2020 онд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдсон энгийн ажил мэргэжилтэй осолдогчдын 71 (71%) нь эрэгтэй, 29 (29%) нь эмэгтэй хүн байна. Мөн үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтны 53 (84.1%) нь эрэгтэй, 10 (15.9%) нь эмэгтэй хүн байна.

## ЗУРАГ 6.5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧ, АЖИЛ МЭРГЭЖЛЭЭР



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Уул уурхай, олборлолтын салбарт осолдогчдын 42.5 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 17.8 хувь нь энгийн ажил, мэргэжил, 15.1 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 12.3 хувь нь техникч болон туслах, дэд мэргэжилтэн, 5.5 хувь нь мэргэжилтэн, 2.7 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, үлдсэн 4.1 хувь нь бусад мэргэжлийн хүн байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 38.9 хувь нь энгийн ажил, мэргэжил, 30.6 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 19.4 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 5.6 хувь нь техникч болон



туслах, дэд мэргэжилтэн, 2.8 хувь нь мэргэжилтэн болон контор, үйлчилгээний ажилтай хүн байна.

Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 59.1 хувь нь энгийн ажил, мэргэжил, 11.4 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 9.1 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан болон мэргэжилтэн, 6.8 хувь нь техникч болон туслах, дэд мэргэжилтэн, 2.3 хувь нь контор, үйлчилгээний ажилтай хүн байна.

#### ХҮСНЭГТ 6.6. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, ЭЗҮА-НЫ САЛБАР, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР, 2020 ОН

Салбар	Бүгд	Мэргэжилтэн	Техникч болон туслах, дэд мэргэжилтэн	Контор, үйлчилгээний ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	Энгийн ажил, мэргэжил	Бусад
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6	-	-	1	1	1	-	3
Уул уурхай, олборлолт	73	4	9	2	11	31	13	3
Боловсруулах үйлдвэрлэл	36	1	2	1	7	11	14	-
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7	-	1	-	2	1	3	-
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5	-	-	-	2	-	3	-
Барилга	43	2	2	-	32	2	5	-
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	8	1	1	-	-	-	-	6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	44	4	3	1	4	5	26	1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3	1	-	-	-	-	1	1
Мэдээлэл, холбоо	4	2	2	-	-	-	-	-
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	6	-	-	3	1	-	1	1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3	-	-	-	-	-	-	3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	53	4	-	2	-	-	7	40
Боловсрол	14	2	-	3	-	-	7	2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	24	7	-	4	-	-	13	-
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	-	-	-	-	-	1	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23	1	2	3	3	2	6	6
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>353</b>	<b>29</b>	<b>22</b>	<b>20</b>	<b>63</b>	<b>53</b>	<b>100</b>	<b>66</b>

Бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 116 (32.9 %) нь унаж бүдрэх халтирах, 59 (16.7%) нь эд зүйлд хавчуулагдах, 31 (8.8%) нь унаж байгаа эд зүйлд цохигдох, 19 (5.4%) нь гаднын халдлагад өртөх, 17 (4.8%) нь хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн, 13 (3.7%) нь халалт, түлэгдэлт, хөлдөлт, 11 (3.1%) нь эд зүйл дээр гишгэх, суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдох, 8 (2.3%) нь цахилгаан гүйдэлд цохиулах, 7 (2%) нь хортой бодис цацраг идэвх нөлөөнд өртөх, 1 (0.3%) нь живх 1 (0.3%), 71 (20%) нь бусад шалтгааны улмаас үүссэн байна.

ЗУРАГ 6.6. ОСОЛДОГЧИД, ОСОЛД ОРСОН ШАЛТГААНААР, 2020ОН




Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

### ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД УЛИРЛААР

2017 оны I улирлаас 2020 оны IV улирлын хооронд нийт 1304 бүртгэгдсэн байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг улирлаар нь авч үзвэл улиралд дунджаар 81 осол бүртгэгдэж байгаа бөгөөд улирлын дунджаар нь авч үзэхэд IV улиралд хамгийн өндөр 111 осол гарсан бол I улиралд 71, II улиралд 73, III улиралд 71 үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэн байна.

Нийт бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 284 (21.8%) нь I улиралд, 290 (22.2%) нь II улиралд, 285 (21.9%) нь III улиралд, 445 (34.1%) нь IV улиралд гарсан байна. Улирлын чиг хандлагыг нь харахад IV улиралд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдох хандлага нь их байна.


ЗУРАГ 6.7. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, НАС БАРАЛТ, УЛИРЛААР, 2017-2020 ОН



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Нас баралтыг 2017 оны I улирлаас 2020 оны IV улирлын хооронд 149 бүртгэгдсэн байна. Нас баралтыг улирлаар нь авч үзвэл 21 (14.1%) нь I улиралд, 31 (20.8%) нь II улиралд, 47 (31.5%) нь III улиралд, 50 (33.6%) нь IV улиралд гарсан байна. 2020 онд 40 хүн нас барсны 3 (7.5%) нь I улиралд, 11 (27.5%) нь II болон III улиралд, 15 (37.5%) нь IV улиралд бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 6.8. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, ХЭЛБЭР, УЛИРЛААР 2020 ОН



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Унах, бүдрэх, халтирах шалтгаанаар 116 хүн осолдсоны 33 (28.4%) нь I улиралд, 19 (16.4%) нь III улиралд, 32 (27.6%) нь II болон IV улиралд бүртгэгдсэн байна.

Эд зүйлд хавчуулагдах шалтгаанаар 59 хүн осолдсоны 11 (18.6%) нь I улиралд, 12 (20.3%) нь II болон III улиралд, 24 (40.7%) нь IV улиралд бүртгэгдсэн байна.

Унаж байгаа эд зүйлд цохигдох шалтгаанаар шалтгаанаар 31 хүн осолдсоны 4 (12.9%) нь I улиралд, 10 (32.3%) нь II улиралд, 9 (29%) нь III улиралд, 8 (25.8%) нь IV улиралд бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 6.7. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, ГАРСАН ШАЛТГААН УЛИРЛААР

Осол гарсан шалтгаан	Бүгд	Улирал			
		I	II	III	IV
Унах, бүдрэх, хальтрах	116	33	32	19	32
Унаж байгаа эд зүйлд цохигдох	31	4	10	9	8
Эд зүйл дээр гишгэх, суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдох	11	4	4	1	2
Эд зүйлд хавчуулагдах	59	11	12	12	24
Хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн	17	3	4	5	5
Халалт, түлэгдэлт, хөлдөлт	13	4	1	4	4
Цахилгаан гүйдэлд цохиулах	8	2	-	1	5
Хортой бодис цацраг идэвхи нөлөөнд өртөх	7	4	1	2	-
Гадны халдлагад өртөх	19	5	6	2	6
Живх	1	-	1	-	-
Бусад	71	14	12	19	26
Дүн	353	84	83	74	112

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Уул уурхай, олборлолтын салбарт 73 хүн осолдсоны 17 (23.3%) нь I болон II улиралд, 5 (6.8%) нь III улиралд, 34 (46.6%) IV улиралд бүртгэгдсэн.

Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 53 хүн осолдсоны 13 (24.5%) нь I улиралд, 16 (30.2%) нь II улиралд, 7 (13.2%) нь III улиралд, 17 (32.1%) нь IV улиралд бүртгэгдсэн байна.

Тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарт 44 хүн осолдсоны 18 (40.9%) нь I улиралд, 5 (11.4%) нь II улиралд, 11 (25%) нь III улиралд, 10 (22.7%) нь IV улиралд бүртгэгдсэн байна.

Тоон мэдээллээс харахад Уул уурхай, олборлолт, Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоор осолдогчдын дийлэнх нь IV улиралд гарсан байна.

#### ХҮСНЭГТ 6.8. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГООР ОСОЛДОГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР УЛИРЛААР, 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд	Улирал			
		I	II	III	IV
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6	3	2	-	1
Уул уурхай, олборлолт	73	17	17	5	34
Боловсруулах үйлдвэрлэл	36	10	7	4	15
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7	2	1	2	2
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5	-	2	1	2
Барилга	43	-	11	19	13
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	8	4	-	1	3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	44	18	5	11	10
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3	-	1	1	1
Мэдээлэл, холбоо	4	-	2	2	-
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	6	1	2	3	-
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	-	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3	-	-	-	3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	-	-	-	-	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	53	13	16	7	17
Боловсрол	14	6	1	3	4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	24	6	10	3	5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	-	1	-	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23	4	5	12	2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	-	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	-	-	-	-	-
ДҮН	353	84	83	74	112

*Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар*